

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/04

Арвайхээр

«Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах»
комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулах тухай

Үндэсний Архивын газрын даргын 2007 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 2.2.2, 2.2.3 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын баримт бичгийн үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтанд баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах зорилгоор байгууллагын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсугай. Үүнд:

Комиссын дарга: Г.Ариунаа (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Улам-Ундрах (Орон нутгийн өмчийн газрын архив, бичиг хэрэг, нярав)

Гишүүд: Т.Эрдэнэсүрэн (Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

А.Баяндүүрэн (Орон нутгийн өмчийн газрын хууль эрх зүй, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн мэдээлэл лавлагаа, хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн програм хариуцсан мэргэжилтэн)

Б.Пүрэвсүрэн (Орон нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээ, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг мөрдөж ажиллахыг баримт бичиг нягтлан шалгах комисс (Г.Ариунаа)-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/02 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Н.ГАНБОЛД

177110007